

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2019 ОНЫ III УЛИРЛЫН ТАЙЛАН**


2019.10.04

Улиастай

Завхан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сум байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлыг "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу иргэдээс мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон амаар, бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг аль болох хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж, өргөдөл, гомдлыг амаар болон бичгээр хүлээн авч шийдвэрлэн хариуг өгч, бусад өдрүүдэд хэлтсийн дарга нар иргэдийг хүлээн авч уулзаж өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллаж байна.


Иргэдээс аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газарт 2019 оны III улиралд 121 өргөдөл ирүүлснээс 110 өргөдлийг шийдвэрлүүлж 11 өргөдөл шийдвэрлэх хугацаа нь хүлээгдэж шийдвэрлэлт 91.6 хувьтай байна.



Нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс 1247 өргөдөл гомдлыг хүлээн авч 1101 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч, 19 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж, 139 өргөдөл хугацаа болоогүй хүлээгдэж байна. Нутгийн

захиргааны байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлт 89.8 хувьтай байна. Цахимаар буюу Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвөөр уламжлан 8, аймгийн Засаг даргын иргэдээ сонсох 70461212 утсанд 125 иргэн хандсан байна.

Өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр дүгнэлт хийж, хяналт



шинжилгээ үнэлгээг хийж биелэлтийг тооцон ажиллаж байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	254	242	25	-	12	95.2%
2	Нутгийн захиргааны байгууллага	1247	1101	19	1	138	89.8%
2019 оны III улирлын дүн		1501	1343	44	1	150	92.4%

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт/хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	ЗГИОНХ төвөөр	Цахим хэлбэрээ	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	254	121	8	-	121	-	-
2	Нутгийн захиргааны байгууллага	1247	1230	0	3	12	12	0
2019 оны III улирлын дүн		1501	1351	8	3	133	12	0

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Завхан аймаг	Нийт 1501 өргөдлөөс Хүсэлт 1186 /79% Санал 285 /19% Гомдол 30 /2% 1. Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйчилгээний жил” болгон зарласан тогтоолыг хэрэгжүүлж аймгийн Засаг даргын “Ард иргэдээ сонсох VI аян”-ны хүрээнд “Төрийн үйлчилгээг багт” арга хэмжээг 2019 оны 08 дугаар сарын 03-20-ны өдрийг хүртэлх хугацаанд 23 сумын хөдөөгийн 88 багт зохион байгуулсан 2. Хэлтэс, агентлаг, албан байгууллагын удирдах ажилтнуудыг хамруулан зохион байгуулдаг “Шуурхай хурал”-аар иргэдээ сонсох 70461212 утсанд хандсан асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Л.ЛХАМСҮРЭН

ТАЙЛАНГ НЭГТГЭЖ БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.ЯДАМЦОО